

БНМАУ-ЫН БААТАР ЦОЛ

Х. Өрнөх

Товч утга: БНМАУ-ын төрийн дээд шагналд баатар хэмээх эрхэм дээд алдар цолыг хэрэглэх явдал ардын засгийн жилүүдэд үүсч хөгжсөн байна. Улсын баатар цол нь улс орныг батлан хамгаалах үйл хэрэгт их хувь нэмэр оруулсан, онцгой гавьяа байгуулсан иргэдийг шагнах төрийн эрхэм дээд алдар цол бөгөөд БНМАУ-ын шагналын тогтолцооны чухал хэсэг байжээ.

Түлхүүр үг: Улсын Бага Хурал, Улсын баатар цол шагнах дүрэм, баатар цолтны тэмдэг

Монгол Улсын баатар хэмээх алдар цолыг анх 1911 оноос Богдхаант Монгол Улсын засгийн газраас олгож эхэлжээ. “Баатар” хэмээх алдар цолыг 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд төрийн эрхийг авсан Ардын засгийн газраас үргэлжлүүлэн шагнаж байжээ. Ардын засгийн анхны баатар цолоор 1922 онд үндэсний ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг, тухайн үеийн Бүх цэргийн жанжин Д. Сүхбаатарыг шагнасан бол хоёр жилийн дараа Цэргийн яамны сайд С. Магсаржавыг “Ардын хатан баатар” цолоор шагнасан байна. Гэвч тухайн үед баатар цолтны эрх үүрэг, эдлэх хөнгөлөлт зэргийг зохицуулсан журам, баатар цолтныг бусдаас ялгах одон тэмдэг, үнэмлэх бичиг байгаагүй байна. Харин баатрын алдар цолыг дагалдуулан нэг удаагийн мөнгөн урамшуулал олгож байжээ. Жишээ нь, Цэргийн яамны сайд С. Магсаржавт “Ардын хатан баатар” цолоор шагнасныг холбогдуулж 1000 лан цэвэр мөнгийг засгийн газраас шийтгэн олгосон байна¹.

БНМАУ-ын баатар цолыг буй болгосон тогтоолыг Улсын Бага Хурал /УБХ/-ын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн хамтарсан 14 дүгээр хурлаар 1936 оны 2 дугаар сарын 14-ний өдөр батлажээ. Уг тогтоолын 2 дугаар зүйлд “Улсын баатар цолыг улсын ба ард түмний төлөө дайсан этгээдүүдийг онц баатарлагаар байлдан дарж цусан гавьяа байгуулсан хүмүүст шагнаж олгох” гэж заажээ. Түүнчлэн улсын баатар цолыг шагнах эрхийг хоёр субъектэд олгожээ. Үүнд, корпус командлан захирагчаас дээш буюу цэргийн дээд удирдах албан тушаалтанд Улсын баатар цолыг УБХ-ын Тэргүүлэгчдийг тогтоолоор, корпус

¹ Д.Догсомжав, Мөнх дурсагдах үйлстнүүд, Улаанбаатар, 2007, х,49.

командлан захирагчаас доош албан тушаалын хүмүүст Бүх цэргийн жанжны тушаалаар олгохоор заасан байна². БНМАУ-ын баатар цолны журам, баатар цолтны тэмдэг 1941 онд батлагдах хүртэл БНМАУ-ын баатар цолоор шагнагдагдсад УБХ-ын Тэргүүлэгчдээс тусгайлан баатрын тэмдэг, үнэмлэх олгоггүй зөвхөн Цэргийн гавьяаны одонгоор шагнаж байв.

БНМАУ-ын анхны баатар цолыг 1936 оны эхээр Монгол ардын хувьсгалт цэрэг /МАХЦ/-ийн бага дарга Шагдарын Гонгор хүртсэн байна. Тэрээр зүүн хязгаарт хилийн манааны үүрэг гүйцэтгэж байхдаа гадаадын тагнуул, туршуулын бүлэгтэй тулгаран эрэлхгээр байлдаж тэдэнд хохирол учруулан буу зэвсэг, чухал баримт бичиг олзлон авсан учраас БНМАУ-ын баатар цолоор шагнуулжээ.

БНМАУ-ын удаах баатар цолоор МАХЦ-ийн нисэх хүчний ангийн дарга хурандаа Д. Дэмбэрэл 1935-1937 онд зүүн хязгаарын хилийн тулгаралтын агаарын тулалдаанд гавьяа байгуулсаны төлөө “БНМАУ-ын агаарын зоригт баатар” цолоор шагнуулсан байна.

1940 оны Улсын 8 дугаар их хурлаар БНМАУ-ын Үндсэн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус улсын шагналын асуудлыг УБХ-ын Тэргүүлэгчид дагнан хариуцах болсон. Мөн шинэ Үндсэн хуулиар БНМАУ-ын төрийн сүлдийг өөрчлөн баталсан тул улсын одон тэмдгийг загварыг шинэчлээд зогсохгүй одон тэмдгийн дүрмийг шинэчлэх, шинэ тэмдэг /медаль/ буй болгох шаардлага үүсжээ. Улмаар 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдөр УБХ-ын Тэргүүлэгчдээс БНМАУ-ын баатар цолтны анхны дүрэм, Улсын баатар цолтны тэмдгийн загварыг хэлэлцэн баталсан байна.

Улсын баатар цолны дүрмийг 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдөр УБХ-ын Тэргүүлэгчдийн 43 дугаар тогтоолоор баталжээ. Уг дүрэм нь Улсын баатар цол олгох ерөнхий үндэслэл, Улсын баатрын тэмдгийн тодорхойлолт, Улсын баатар цолтны хүлээх үүрэг, эдлэх эрх, хөнгөлөлтийг заасан 7 зүйлээс бүрдэж байв. “БНМАУ-ын баатар” хэмээх цол шагнасан олгох журмын 3 дугаар зүйлд Улсын баатрын тэмдгийг тодорхойлохдоо “БНМАУ-ын баатрын медаль тэмдэг болвоос шар таван хошууны төв дунд нь Сүхбаатарын биеийн товойсон дүрстэй бөгөөд нүүр тал нь хөх өнгөтэй, дээр нь *БНМАУ-ын баатар* хэмээсэн үг бүхий улаан туг байваас зохимой” гэжээ³.

БНМАУ-ын УБХ-ын Тэргүүлэгчдээс Улсын баатрын тэмдгийг 1940 онд БНМАУ-аас ЗХУ-д суугаа Элчин сайд Ж. Самбуугаар дамжуулан Москва хотын Зоос гоёлын үйлдвэрт нийт 26 ширхэгийг захиалан үйлдүүлж 1941-1945 онд шагнаж байжээ⁴. БНМАУ-ын баатар цолны дүрэм, баатар цолтны тэмдгийг 1945

² Ц.Тэрбиш, БНМАУ-ын одон, медаль, алдар цол, түүнийг анх хүртэгчид, Улаанбаатар, 1977, х.79.


³ УТА. Ф-11, Д-1, хн 458.

⁴ УТА.Ф-11, Д-1, хн 656.

онд шинэчлэн батлагдах хүртэл БНМАУ-ын баатар цолоор шагнагдагсад УБХ-ын Тэргүүлэгчдээс Улсын баатрын дээрх тэмдгийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгийн хамт дагалдуулан шагнаж байв.



БНМАУ-ын баатрын тэмдгийн анхны загвар



МАХЦ-ийн байлдагч Д. Данзанваанчиг, байлдагч С. Дампил нар Улсын баатар цолоор шагнагдсаны дараа. 1945 он.

1945 онд УБХ-ын Тэргүүлэгчдээс БНМАУ-ын шагналын тогтолцоог шинэчлэх шийдвэр гаргаж тус улсын дээд шагнал-Сүхбаатарын одон, Цэргийн гавьяаны одон, Японыг ялсаны төлөө медалийг шинээр буй болгосон байна. Түүнчлэн Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Улсын баатрын тэмдгийн загварыг өөрчилж, дээрх одон тэмдгийн дүрмийг шинэчлэн баталжээ.


БНМАУ-ын баатрын “Алтан таван хошуу” тэмдгийн тодорхойлолтыг УБХ-ын Тэргүүлэгчдээс 1945 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 91 дүгээр хурлын тогтоолоор баталсан байна⁵. Үүнд:

1. БНМАУ-ын баатрын тэмдэг бол дээд талдаа цагаан судалтай улаан лент бүхий үнэт эрдэнийн чулуугаар чимэгдсэн цул алтан таван хошуу байна.
2. Эл баатрын алтан тэмдгийг товойлгож үйлдсэн байх бөгөөд алтан таван хошууны нэг үзүүрээс нөгөө үзүүр хүртэл 32 мл байна. Лентний хамт эл баатрын тэмдгийн урт нь 55 мл байна.
3. Эл баатрын тэмдгийн алтан таван хошуу нэг бүрт хоёр богино салааг дагалдуулан гаргаж товойлгон хийнэ.
4. Эл баатрын тэмдгийн таван хошууны завсар дахь гурван өнцөг бүхий цацрал дээр каратын $3/2$ орчим хэмжээний олон өнцөг булан бүхий гялтагнасан очир алмаз чулуу шигтгээ суулгана.
5. Эл баатрын тэмдгийн алтан таван хошууны дээд талд цэвэр алтан хүрээтэй цагаан судалтай улаан торгон лент байна. Энэ лентийн хүрээний дээд хөндлөн нь 25 мл, богино дагуугийн хэмжээ нь 10 мл, дээд голоос доод туйлын гурвалжин үзүүр хүртэл 20 мл байна.
6. Баатрын тэмдгийн торгон лент нь баруун зүүн хажуугаараа цагаан өнгийн хос дагуу зурвастай байна.
7. Баатрын тэмдгийн ард дэс дугаар ба дээд хэсгийн ард эрэгтэй шураг байна.

БНМАУ-ын баатар цолны дүрмийг УБХ-ын Тэргүүлэгчдээс 1946 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд уг дүрмийг доор бүрэн эхээр толилуулав. Үүнд:

1. Эх орноо хамгаалах хэрэгт амь бие хайрлалгүй зүтгэж онцын эрэлхэг зоргийг гаргасан ба мөн түүнчлэн БНМАУ-ын ардын хувьсгалт байгуулал, түүний эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэх хэрэгт онц гарамгай гавьяаг байгуулсан хүнд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс БНМАУ-ын баатар цолыг шагнана.

⁵ БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, СнЗ-ийн тогтоолын эмхэтгэл, Улаанбаатар, 3-4-р боть, 1945 он. х. 50-56.



БНМАУ-ын баатрын “Алтан таван хошуу” тэмдэг

2. БНМАУ-ын баатар цолоор шагнагдсан хүнд зохих үнэмлэхийг олгохын хамт Сүхбаатарын одон, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатарын тэмдгийг гардуулан өгнө.

3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар цолоор шагнагдсан хүмүүс БНМАУ-ын баатрын тэмдгийг цээжний зүүн талд зүүнэ. Энэ тэмдгийг баяр жагсаал, хувьсгалын баяр ёслол, баярын хурлуудад заавал зүүнэ.

4. БНМАУ-ын баатар цолоор шагнагдсан хүмүүс тус улсын одонгуудаар шагнагдсан хүнээс одон тэмдгүүдийн ерөнхий дүрмийн ёсоор эдэлдэг бүхий л эрх хөнгөлөлт зэргийг нэгэн адил эдлэнэ.

5. Урьд БНМАУ-ын баатар цолоор шагнагдсан хүмүүсээс баатарлаг гавьяаг дахин байгуулахад нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хошой баатар цол шагнаж баатрын тэмдэг, Сүхбаатарын одонг тус тус олгохын хамтад тэрхүү шагнагдсан хүний цээж дүрийг түүний төрсөн нутгийн сумын төвд босгон байгуулна.

6. БНМАУ-ын баатар гэсэн хүндэт цолоор шагнагдагчид бол тус улсын үндсэн хууль ба бусад хуулиудад заасан тус улсын иргэний бүх үүргийг гүйцэтгэн биелүүлэхэд өөрсдийн биесээр үлгэр жишээ үзүүлбэл зохино.

7. БНМАУ-ын баатар цолыг ганцхүү Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хасна. Үүнд: шүүх таслах газрын тогтоол буюу мөн шагнагдагчдаас нэр хүндээ гутаасан явдлыг өдүүлэх нь Улсын баатар цолыг хасах тухайн шийдвэрийг гаргахад үндэс болно.

8. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдөр БНМАУ-ын баатар цолыг шагнах журмын тухай гаргасан 43 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд батлав.

БНМАУ-ын баатрын “Алтан таван хошуу” тэмдгийн эскизийг зураач Д. Чойдог зохиосон бөгөөд тэрээр өөрөө 1945 онд ЗХУ-ын Москва хотын Зоос гоёлын үйлдвэрт очиж бусад одон тэмдгийн хамт захиалан үйлдүүлжээ⁶. Уг тэмдгийг 1945-1985 оны хооронд нийт 50 ширхэгийг ЗХУ-д захиалан үйлдвэрлүүлсэн байна⁷.

1945 оны 10 дугаар сараас БНМАУ-ын баатар, хожим Монгол Улсын баатар цолтонд “Алтан таван хошуу” тэмдгийг Сүхбаатарын одон, баатрын үнэмлэхийн хамт олгож байна.

1992 он гэхэд БНМАУ-ын баатар эрхэм алдар цолоор нийт 58 иргэн шагнуулсан байна. Эдгээр 58 иргэнээс хоёр нь эмэгтэй, 17 иргэн нь хуучин ЗХУ-ын иргэд байв. БНМАУ-ын УБХ, хожим Ардын Их Хурал /АИХ/-ын Тэргүүлэгчдээс 58 иргэнд БНМАУ-ын баатар цол олгохдоо 17 иргэнийг нэхэн шагнажээ. БНМАУ-ын баатар цолоор нэхэн шагнагдсан ихэнх хүмүүсийн ар гэрийнхэнд нь БНМАУ-ын баатрын тэмдэг, Сүхбаатарын одонг олголтгүй зөвхөн Баатар цолтны үнэмлэхийг дурсгал болгон хадгалуулж байв. Нийт БНМАУ-ын баатар цол хүртсэн иргэдээс ганц хүн буюу БНМАУ-ын маршал Х. Чойбалсан Улсын баатар цолоор хоёр удаа шагнуулжээ. Харин Улсын баатар, Хөдөлмөрийн баатар цолны аль алинаар шагнагдсан ганц хүн нь БНМАУ-ын маршал Ю. Цэдэнбал байна. БНМАУ-ын баатар цол буй болсноос хойш маршал Ю. Цэдэнбал, хурандаа Л. Дандар нар энэхүү эрхэм алдар цолоо хураалгасан хэдий ч хожим холбогдох дээд байгууллагаас цолыг нь тэдэнд сэргээн олгосон байна.

⁶ П.Балдандорж, И.Зориг, Урчуудын эвлэлийг үндэслэгч Д.Чойдог, Улаанбаатар, 2006.


⁷ УТА.Ф-11, Д-2, хн -1039.



*БНМАУ-ын баатар хошууч Ж.Нэхийт
“Алтан таван хошуу” медаль, түүний
лентийг зүүсэн байгаа нь*

1944 оны 11 сард БНМАУ-ын одон, медалийн лент /тууз/ буй болгохоос өмнө хүмүүс одон, тэмдгээ өдөр тутамд жилийн дөрвөн улиралд зүүх шаардлагатай байдаг байв. Одонгоор олон удаа шагнуулсан хүмүүс одон, тэмдгээ байнга зүүх нь хүндрэлтэй, нөгөөтэйгүүр ЗХУ-д одон, медалийн лентийг 1943 онд батлаж хэрэглэсэн нь УБХ-ын Тэргүүлэгчдээс БНМАУ-ын одон, тэмдгийн лентийн загвар, лент зүүх дүрмийг боловсруулж батлахад нөлөөлжээ. УБХ-ын Тэргүүлэгчдээс 1944 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн тогтоолоор БНМАУ-ын одон, тэмдгийн лентийг, мөн Тэргүүлэгчдийн 1945 оны 12 дугаар сарын 17-ны өдөр одон,

тэмдгийн лентийг зүүх дүрмийг тус тус баталжээ⁸. Уг дүрэмд Улсын баатрын тэмдгийн лентийг бусад одон, тэмдгийн лентийн дээд талд төвлөрүүлж зүүнэ гэж заасан байна.



БНМАУ-ын баатрын “Алтан таван хошуу” тэмдгийн лент

БНМАУ-ын баатрын тэмдгийн лентийг бусад одон тэмдгийн лентийн адил ЗХУ-д 1945-1946 онуудад захиалан хийлгэжээ. Уг лент нь алтадсан гууль,

⁸ БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, СнЗ-ийн тогтоолын эмхэтгэл, Улаанбаатар, 3-4-р боть, 1945 он. х.80-81.

төмөрөөр хийгдсэн бөгөөд 35 мл өргөнтэй 12 мл өндөртэй, нүүр тал нь гүн улаан өнгийн паалангаар бүрэгдсэн, төв дундаа алтадсан таван хошууны хэлбэртэй, түүний хоёр талын босоо зурвас нь цагаан өнгийн паалантай хас хээтэй байна. Лент нь ард талдаа хувцасанд зүүж тогтоох зүүтэй болно. Энэхүү лентийг БНМАУ-ын хошой баатар маршал Х. Чойбалсан, БНМАУ-ын баатар хурандаа Ш. Гонгор, хошууч Ж. Нехийт, хошууч Д. Данзанваанчиг, хошууч С. Дампил нарт олгож байжээ.

Abstract: The award system of Mongolia originates from the 12th century. Even before the formation of the Great Mongolian Empire in 1206, the Mongolians conferred titles of “hero”, “sharpshooter”, “wise”, etc to individuals who distinguished themselves in the state and military affairs. The important element of the Mongolian award system, the title of the Hero of Mongolia has been officially conferred by the newly independent Government led by Bogd Javjandamba since 1911 and the honor of bestowing the title of the Hero of the Mongolian People’s has been continued by the “People’s” Government formed as a result of National democratic revolution in 1921. The presented work outlines a brief history of the Mongolian “Hero” title and sheds light on the badges/medals of distinction, the orders, ribbons and title regulations pertaining to this title of honor.

Ашигласан материал

1. БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, СнЗ-ийн тогтоолын эмхэтгэл, Улаанбаатар, 3-4-р боть, 1945 он. х. 50-56. х.80-81.
2. Д.Догсомжав, Мөнх дурсагдах үйлстнүүд, Улаанбаатар, 2007, х,49.
3. Ц.Тэрбиш, БНМАУ-ын одон, медаль, алдар цол, түүнийг анх хүртэгчид, Улаанбаатар, 1977, х.79.
4. П.Балдандорж, И.Зориг, Урчуудын эвлэлийг үндэслэгч Д.Чойдог, Улаанбаатар, 2006.
5. Р.Шейн. Ц.Содномдаржаа. “БНМАУ-ын шагнал”. УБ. 1984 он.
6. И. Викторов-Орлов. “БНМАУ-ын шагналууд”. Горький хот. 1990 он.
7. Dietrich Herfurth. Soviet awards and Awards of MPR: a catalogue. Elch Graphics. 2004. Berlin.
8. Ж.Болдбаатар. Одон медаль судлалын тухайд. “Түүх зулсан он жилүүдийн ойллого”. Нэгдүгээр боть. УБ. 2003 он.
9. А. Battushig. Mongolian Orders, Medals and Badges. Ulaanbaatar. 2005.
10. Ш.Хэнмэдэх, П.Төмөрбаатар. “Алдар гавьяатны өргөө”. УБ. 2003 он.
11. УТА. Ф-11, Д-1, ХН- 458.
12. УТА, Ф -11, Д-2, ХН-1039.